



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын орлогчийг томилох  
эрх бүхий албан тушаалтнуудыг шинэчлэн тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.13 дах заалт, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Дүрмийн 9.4.7, 9.4.11, 11.1.4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн Нэр дэвшүүлэх хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Конвинеенс дэлгүүрийн бизнесийн үйл ажиллагаа хариуцсан захирал Г.Чинзоригийг 2024 оны 03-р сарын 05-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, Компанийн Гүйцэтгэх захирлын орлогчоор томилсугай.
2. Компанийн эрх бүхий албан тушаалтнаар дараах албан тушаалтнууд тооцогдохоор шинэчлэн баталсугай. Үүнд:
  - (i) ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга;
  - (ii) Гүйцэтгэх захирал;
  - (iii) Санхүү хариуцсан захирал; болон
  - (iv) Гүйцэтгэх захирлын орлогч.
3. Компанийн Гүйцэтгэх захирлын орлогч, эрх бүхий албан тушаалтны жагсаалтад орсон өөрчлөлтийг холбогдох зохицуулагч, бүртгэгч байгууллагуудад мэдэгдэх, бүртгэл хийлгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д даалгасугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХАРААТ БУС ДАРГА



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

ГАРИ БИОНДО

А.ГАНХУЯГ

А.ГАНБОЛД

Г.БАТ-ЭРДЭНЭ

З.УЯНГА

Г.ЧИНЗОРИГ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

В.ГАНЗОРИГ